



**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР**

**ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ ТӨВҮҮДИЙН
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
СУДАЛГАА**

**Улаанбаатар хот
2018 он**

Хянасан : С.Болорцэцэг /Сургалт, судалгаа мэдээллийн төвийн захирал/

Боловсруулсан: О.Ганболд /ХХХ-ын бодлогын судалгаа шинжилгээ хариуцсан судлаач/

С.Зулцэцэг /ГБЗ-ын бодлогын судалгаа шинжилгээ хариуцсан судлаач/

Мэдээлэл цуглуулсан: Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар
Аймаг, дүүргийн ГБХЗХ-ийн газар, хэлтсүүд

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ХАРЬЯА СУРГАЛТ СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Улаанбаатар, Монгол Улс

И-Мэйл: fcy.gov.mn

Засгийн Газрын XI байр,

<https://www.facebook.com/ГБХЗХГ/>

Утас: 62263097, 262109, 262209

АГУУЛГА

Хүснэгт, зургийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

Бүлэг 1. Ерөнхий тойм

- 1.1 Судалгааны үндэслэл
- 1.2 Судалгааны зорилго, зорилт
- 1.3 Судалгааны хугацаа
- 1.4 Судалгааны товч дүн
- 1.5 Судалгааны хамрах хүрээ
- 1.6 Судалгааны мэдээлэл боловсруулалт

Бүлэг 2. Өдөр өнжүүлэх төвүүдийн өнөөгийн нөхцөл байдал

- 2.1 Өдөр өнжүүлэх төвүүдийн ерөнхий мэдээлэл
- 2.2 Өдөр өнжүүлэх төвүүдийн багш нарын мэдээлэл
- 2.3 Өдөр өнжүүлэх төвийн хүүхдүүдийн мэдээлэл
- 2.4 Хүүхэд хамгаалал, аюулгүй байдал

Бүлэг 3. Хэрэглэгчийн үнэлгээ (эцэг, эх)

- 3.1 Эцэг, эхчүүдийн ерөнхий мэдээлэл
- 3.2 Эцэг эхчүүдийн үнэлгээ

Бүлэг 4. Дүгнэлт

- 4.1 Дүгнэлт

Хавсралт

Судалгааны асуулгууд

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 2.1.1 Өдөр өнжүүлэх төвүүдийн газар зүйн байршил, хот хөдөөгөөр, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.1.2 Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагаа явуулдаг эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.1.3 Өдөр өнжүүлэх төвүүдийн байрны орчин нөхцөл, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.1.4 Өдөр өнжүүлэх төвүүдийн байрны талбайн хэмжээ, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.1.5 Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагаа явуулсан хугацаа, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.1.6 Өдөр өнжүүлэх төвүүдийн сарын дундаж төлбөр, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.1.7 Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх хөтөлбөрүүд, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.1.8 Өдөр өнжүүлэх төвүүдийн багшийн тоо, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.2.1 Багшийн хүйсийн харьцаа, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.2.2 Багшийн боловсролын төвшин, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.2.3 Насны бүлэг, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.2.4 Нийт ажилласан жил, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.2.5 Эзэмшсэн мэргэжил, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.2.6 Давхар ажил эрхлэлт, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.3.1 Хүүхдийн насны бүлэг, дүнд эзлэх хувиар
 - Зураг 2.3.2 Өдөр өнжүүлэх төвд хамрагдсан хугацаа, дүнд эзлэх хувиар
 - Зураг 3.1.1 Эцэг эхийн ажил эрхлэлт, дүнд эзлэх хувиар
 - Зураг 3.1.2 Хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чаддаг эсэх
 - Зураг 3.1.3 Хүүхдийн тоо, дүнд эзлэх хувиар
 - Зураг 3.1.4 Өдөр өнжүүлэх төвд явдаг хүүхдийн тоо, дүнд эзлэх хувиар
 - Зураг 3.1.5 Өдөр өнжүүлэх төвд хамрагдсанаар үр дүн, эерэг өөрчлөлт гарсан эсэх
 - Зураг 3.1.6 Өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагааг бүхэлд нь үнэлнэ үү?
 - Зураг 3.1.7 Хүүхдүүд өдөр өнжүүлэх төвд хэдэн цаг явдаг, дүнд эзлэх хувиар
 - Зураг 3.1.8 Хоол ундны чанарын үнэлгээ, дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 2.4.1 Хүүхэд хамгаалал, аюулгүй байдал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГБХЗХГ	Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар
НХГБХГ	Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар
ССМТ	Сургалт, судалгаа мэдээллийн төв
ХХХ	Хүүхэд хөгжил, хамгаалал
ГБЗ	Гэр бүл, залуучууд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ӨӨТ	Өдөр өнжүүлэх төв



БҮЛЭГ I

ЕРӨНХИЙ ТОЙМ

1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Өдөр өнжүүлэх төвийн ач холбогдол сургуулийн өмнөх боловсролтой дүйх хэмжээний чухал ач холбогдолтой байдаг. Эдгээр төвүүдэд хөгжил, төлөвшилтийнхөө гол суурийг олж авах насан дээрээ яваа хүүхдүүд хамрагдаж байна.

Өдөр өнжүүлэх төв нь хичээлийн хөтөлбөрөөс гадуур хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах аюулгүй орчин байх шаардлагатай. Гэтэл энэ хэрэгцээг өдөр өнжүүлэх төвүүд хангаж чадаж байна уу, тэнд хүүхэд хөгжүүлэх хөтөлбөр байна уу, ямар стандарт, хяналт, дүрэм, журмаар зохицуулж байна вэ гэдэг нь тодорхой биш байна.

Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 3.1.19-д “өдөр өнжүүлэх үйлчилгээ” гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу сургалтын байгууллага иргэнтэй харилцан тохиролцож үйлдсэн гэрээний үндсэн дээр эрүүл, аюулгүй орчинд хүүхдийг асрах, хамгаалах, хөгжлийг дэмжих сургалтаас гадуур үзүүлэх үйлчилгээг; хэлнэ гэж заасан байдаг.

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд, Хөдөлмөрийн сайдын 2013 оны хамтарсан тушаалаар батлагдсан журамд сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, сургалтын байгууллагыг хэрхэн бүртгэх асуудлыг тусгасан байдаг. Уг журамд заасан бичиг баримтыг бүрдүүлж харьяа дүүргийнхээ боловсролын газар хандаж өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагаа явуулах эрх авах учиртай. Гэхдээ өнөөгийн нөхцөлд өдөр өнжүүлэх төв байгуулахын тулд энэ олон төвөгтэй шалгууруудыг давах шаардлагагүй байна. Учир нь зөвшөөрөл олгох эрхзүйн орчин, зөвшөөрөл өгөх байгууллага нь байгаа ч энэ бүхнийг нэгтгэн хариуцах хяналтын механизм алга байна.

Өөрөөр хэлбэл, цэвэр итгэлцлийн үндсэн явагдаж байгаа тул хүүхдийн эрх, аюулгүй байдал зөрчигдвөл хариуцах эзэн хууль, журмын хүрээнд байхгүй байна.

Иймд Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өдөр өнжүүлэх төвүүдэд эрх олгох, магадлан итгэмжлэх тухай журам боловсруулах, өдөр өнжүүлэх төвүүдийн жишиг стандартыг боловсруулж, нэгдсэн журмаар батлах гэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааг судлах, өдөр өнжүүлэх төвийн тоон мэдээ, түүнд хамрагдаж байгаа хүүхдийн бүртгэл мэдээлэл гаргах, хөгжлийн хөтөлбөртэй эсэх, гадаад, дотоод орчны эрүүл ахуй, аюулгүй байдал, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн газар, Нийслэлийн Хүүхэд, Гэр бүл хөгжлийн газартай хамтран энэхүү судалгааг хийлээ.

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, өдөр өнжүүлэх төвүүдийн жишиг стандарт, магадлан итгэмжлэх тухай журам боловсруулах болон цаашид авах арга хэмжээнд шаардлагатай мэдээллийг цуглуулж, дүгнэлт гаргахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах 6 зорилтыг дэвшүүлсэн болно.

- Өдөр өнжүүлэх төвүүдийн тоог аймаг, нийслэлээр тодорхойлон гаргах
- Өдөр өнжүүлэх төвд хамрагддаг хүүхдүүдийн тоог нас, хүйсийн ялгаатай байдлаар тогтоох
- Орон байрны орчин, хүүхдийн хөгжил, хамгааллын нөхцөл байдлыг үнэлэх
- Багшлах боловсон хүчний ажлын туршлага, боловсролын төвшнийг тодорхойлох
- Эцэг эхчүүдийн өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох
- Өдөр өнжүүлэх төвүүдэд шаардлагатай хэрэгцээт сургалтыг тодорхойлох

1.3 СУДАЛГААНЫ ХУГАЦАА

Судалгааны мэдээллийг 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд цуглуулж 11 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд аймаг болон нийслэлийн газар хэлтсүүд цуглуулсан мэдээллээ ирүүлсэн болно.

1.4 СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮН

Улсын дүнгээр 282 өдөр өнжүүлэх төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 227, орон нутгийн 14 аймагт 55 өдөр өнжүүлэх төв тус тус ажиллаж байна. Эдгээр төвүүдэд нийт 5314 хүүхэд хамрагдаж байгаагийн 85 хувь буюу 4480 хүүхэд Улаанбаатар хотод, 15 хувь буюу 834 нь орон нутагт хамрагддаг ба нэг өдөр өнжүүлэхэд дунджаар 18 хүүхэд хамрагдаж байна.

Хүйсээр нь авч үзвэл 52 хувь нь эрэгтэй, 48 хувь нь эмэгтэй бөгөөд 75 хувь нь 6-8 насных, 24 хувь нь 9-12 насныхан байна. Хүүхдүүдийн дийлэнх буюу 80 хувь нь анхны жилдээ, 10 хувь нь 2 дахь жилдээ, 5 хувь нь 3 болон түүнээс дээш жил өдөр өнжүүлэх төвд хамрагдаж байна. Сарын дундаж төлбөрийн хувьд 66 хувь нь 100.000-200.000₮, 25 хувь нь 201.000-300.000₮, 8 хувь нь 100.000₮ хүртэлх, 1 хувь нь 300.000-400.000₮-ын хооронд тус тус хэлбэлзэж байгаа ба дундаж төлбөр 165.000₮ төгрөг байна. Сарын төлбөрийн хамгийн бага нь 20.000 төгрөг байгаа бол хамгийн өндөр нь 400.000 төгрөгийн төлбөртэй байна. Улсын хэмжээнд төлбөргүй нэг өдөр өнжүүлэх төв байгаа бөгөөд энэ нь гадаад хүний нэр дээр бүртгэлтэй байгаа нь анхаарал татаж байна.

Өдөр өнжүүлэх төвүүдийн 53 хувь нь 2 хүртэлх, 20 хувь нь 2-3, 9 хувь нь 3-4, 18 хувь нь 4 болон түүнээс дээш жилдээ тус тус ажиллаж байгаа бөгөөд тэдний ажилласан дундаж хугацаа 2.9 жил, хамгийн олон жил үйл ажиллагаа явуулсан нь 14 жил байна. Эндээс тогтвортой үйл ажиллагаа явуулдаг өдөр өнжүүлэх төвүүд цөөн байна. Мөн 88 хувь нь 10-15 цагаар ажилладаг бол 10 хувь нь 6-9 цаг, 2 хувь нь 3-5 цаг ажиллаж байна. Өөрөөр хэлбэл 9/10 нь уртасгасан цагаар ажилладаг, хүүхдүүд хичээлээс гадуур ихэнх цагаа өдөр өнжүүлэх төвд өнгөрүүлж байна.

Төвүүдийн орчин нөхцөлийн хувьд 23 хувь нь өөрийн эзэмшлийн, 77 хувь нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 46 хувь нь орон сууцны нэг давхарт, 25 хувь нь орон сууцны 2 болон түүнээс дээш давхарт, 8 хувь нь албан байгууллага, сургууль цэцэрлэгийн байранд, 6 хувь нь бие даасан байранд, 4 хувь нь орон сууцны өргөтгөлд үйл ажиллагаа явуулж байна. Эндээс үзэхэд гурван өдөр өнжүүлэх төв тутмын хоёр нь хүн амьдрах зориулалттай орон сууцны нэг болон хоёроос дээш давхрын байр засаж тохижуулан үйл ажиллагаа явуулж байна.

Талбайн хэмжээгээр авч үзвэл 51 хувь нь 51-100 мк², 33 хувь нь 12-50 мк², 11 хувь нь 101-200 мк², 5 хувь нь 201 мк²-аас дээш байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дундаж талбайн хэмжээ нь 70 мк² байна. Хамгийн их талбайтай нь 2000 мк², хамгийн бага нь 12 мк² талбайтай байна.

Өдөр өнжүүлэх төвүүдэд нийт 537 багш ажиллаж байгаагийн 3 хувь нь давхар ажил эрхэлдэг ба тэдний дийлэнх нь ЕБС-д багшилж байна. Багш нарын 95 хувь нь эмэгтэй, 5 хувь нь эрэгтэй байна. Насны хувьд 51 хувь нь 35-аас дээш насны хүмүүс байсан боловч ер нь өдөр өнжүүлэх төвийн багш нарын бүрэлдэхүүн бүх насыг хамарч байна. Түүнчлэн хоёр багш тутмын нэг нь улсад ажилласан хугацаа нь 10 болон түүнээс дээш жил байна. Энэ нь өдөр өнжүүлэх төвийн багшаар ажлын туршлагатай хүн голдуу ажилладаг болохыг харуулж байна. Мөн багш

нарын 92 хувь нь дээд боловсролтой үүнээс 75 хувь нь багшийн мэргэжилтэй бөгөөд багш мэргэжилтэй хоёр хүний нэг нь бага ангийн багш мэргэжилтэй байна. Үүний дараагаар цэцэрлэгийн болон монгол хэлний багш нар түгээмэл байна.

Нийт төвүүдийн 30 орчим хувь нь шатар, гар урлал уран зураг, IQ, гитар, төгөлдөр хуур гэх мэт хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөртэй байна.

Өдөр өнжүүлэх төвүүдийн 15 хувь нь хүүхэд хамгааллын бодлогын дүрэмтэй бөгөөд тэдний 80 хувь нь ажилтнуудад хүүхэд хамгааллын дүрмийг мөрдөж ажиллах гарын үсэг зуруулж, байгууллагын самбарт ил байрлуулсан байна. Мөн эцэг эх, багш нарын хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг албан ёсоор баталгаажуулах байдал хангалтгүй байгаа бөгөөд хоёр өдөр өнжүүлэх тутмын нэг нь хүүхдийн анкетын мэдээлэл, эцэг эхтэй байгуулсан гэрээ, гурван өдөр өнжүүлэх тутмын нэг нь үйл ажиллагааны дотоод журам, ажилчдын гэрээ огт байхгүй байна.

Түүнчлэн хоёр өдөр өнжүүлэх тутмын нэг нь агааржуулалтын систем, ариун цэврийн булан, ариутгалын бодисын хэрэглээ хадгалалт, сав суулга ариун цэврийн халдваргүйжүүлэлт байхгүй, 75 хувь нь галын дүгнэлт, галын булан, аюулгүй ажиллагааны дүрэм, хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиг байхгүй байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ (Эцэг эхчүүд)

Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааг хөндлөнгөөс дүгнэх зорилгоор хүүхэд нь өдөр өнжүүлэх төвд явдаг 300 эцэг эхчүүдийг судалгаанд хамрууллаа.

Ажил эрхлэлтийн байдлаар 42 хувь нь хувийн хэвшил, бизнесийн байгууллага, 23 хувь нь төрийн байгууллага, 22 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 8 хувь нь ажилгүй байв. Тэдний 35 хувь нь нэг, 31 хувь нь хоёр, 34 хувь нь гурав болон түүнээс дээш хүүхэдтэй бөгөөд 90 хувь нь нэг, 10 хувь нь хоёр хүүхэд өдөр өнжүүлэх төвд хамруулдаг байна. Хүүхдүүдийн 50 хувь нь 5 болон түүнээс дээш, 45 хувь нь 3-5 цагийг тус тус өдөр өнжүүлүүлэх төвд өнгөрүүлдэг байна.

Өдөр өнжүүлэх төв хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чаддаг гэж эцэг эхчүүдийн 92 хувь нь үзсэн ба төвд хамрагдсанаар 60 гаруй хувь нь маш сайн нөлөөтэй, 38 хувь нь нөлөөтэй ч сайжруулах зүйл бий гэж хариулсан нь өдөр өнжүүлэх төвд явах нь хүүхдэд үр өгөөжтэй боловч цаашид сайжруулах зүйл байгаа нь харагдаж байна.

Хоол ундны чанарыг 78 хувь нь хангалттай, 12 хувь нь дунд зэрэг хангалттай гэж үзэж байна. Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааг эцэг эхчүүдийн 87 хувь нь сайн, 8 хувь нь дунд гэж хариулсан нь эдгээр төвүүдийн үйлчилгээ боломжийн сайн байгаа мэт харагдаж байгаа боловч хүүхдүүд тэнд хөгжиж байгаа эсэх, орчин нөхцөл, 1 хүүхдэд ногдож байгаа зай талбай ямар байх, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эцэг, эхчүүдийн ойлголт төдийлөн сайн биш байгаа тул сайн гэсэн хариулт өгч байгаа нь ажиглагдсан.

1.5 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгааны түүвэрлэлтийн хүрээ нь 14 аймаг болон 8 дүүргийн нийт өдөр өнжүүлэх төвүүдийг хамарсан болно. Тухайн аймаг болон дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг эзэмшигчид судалгаанд хамрагдаж, судалгааны асуулгад хариулсан болно. Мөн ӨӨТ-д хүүхдүүд нь хамрагддаг эцэг эхчүүдээс түүвэрлэлт хийн судалгаа авсан болно. Түүнчлэн өдөр өнжүүлэх төв үйл ажиллагаа явуулдаггүй 7 аймаг, 1 дүүрэг байсан бөгөөд үүнд: Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Багахангай зэрэг багтана.

1.6 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ССМТ-д, харин ӨӨТ-үүдээс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг өгөгдсөн зааврын дагуу шалгаж, компьютерт шивж оруулах, шалгах, улмаар засварыг хийсний дараа ССМТ-д дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн ГБХЗ-ын хэлтэс, газрын судалгаа хариуцсан ахлагч, мэргэжилтэн, судлаач нар хийж гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад excel программыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцож гаргах ажилд SPSS20.0 программыг тус тус ашиглан, улмаар статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянаж, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулсан.




БҮЛЭГ II
ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ
ТӨВҮҮДИЙН ӨНӨӨГИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ


2.1 ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ ТӨВҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нийт 282 өдөр өнжүүлэх төвөөс нийслэлийн хэмжээнд 8 дүүргийн нийт 227 өдөр өнжүүлэхийн 26.4 хувь буюу 60 нь Баянгол дүүрэгт, 20.3 хувь буюу 46 нь Сонгинохайрхан дүүрэгт, 15.4 хувь буюу 35 нь Баянзүрх дүүрэгт, 14.5 хувь буюу 33 нь Сүхбаатар дүүрэгт, 11.5 хувь буюу 26 нь Чингэлтэй дүүрэгт, 10.6 хувь буюу 24 нь Хан-Уул дүүрэгт, 0.9 хувь буюу 2 нь Налайх дүүрэгт, 0.4 хувь буюу 1 нь Багануур дүүрэгт тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Харин орон нутгийн 14 аймагт нийт 55 өдөр өнжүүлэхийн 18.2 хувь буюу 10 нь тус тус Хөвсгөл, Архангай аймгуудад, 10.9 хувь буюу 6 нь тус тус Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгуудад, 7.3 хувь буюу 4 нь Говь-Алтай аймагт, 5.5 хувь буюу 3 нь Дорнод аймагт, 3.6 хувь буюу 2 нь тус тус Өмнөговь, Булган, Баянхонгор аймгуудад, 1.8 хувь буюу 1 нь тус тус Төв, Завхан, Хэнтий, Ховд аймгуудад үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 2.1.1 Өдөр өнжүүлэх төвүүдийн газар зүйн байршил, хот хөдөөгөөр, дүнд эзлэх хувиар



Зураг 2.1.2 Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагаа явуулдаг байрны эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувиар



Нийт өдөр өнжүүлэх төвүүдийн 77 хувь нь түрээсийн байранд, 23 хувь нь өөрийн эзэмшлийн байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Ихэнх ӨӨТ-үүд нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг байна.


Нийт өдөр өнжүүлэх төвүүдийн 46 хувь нь орон сууцны 1 давхарт, 25 хувь нь 2 болон түүнээс дээш давхарт, 8 хувь нь албан байгууллага буюу сургууль, цэцэрлэгийн байранд, 6 хувь нь бие даасан байранд үйл ажиллагаа явуулж байна. Өдөр өнжүүлэх төвүүд нь үйл ажиллагаа явуулах зориулалтын байр орчин нөхцөл байхгүй дийлэнх хувь нь орон сууцанд түрээс төлж үйл ажиллагаа явуулж байна гэдэг нь хүүхдэд тохирсон орчин бүрдээгүй байгааг харуулж байна.

Зураг 2.1.3 Өдөр өнжүүлэх төвүүдийн байрны орчин нөхцөл, дүнд эзлэх хувиар




Талбайн хэмжээгээр 51 хувь нь 51-100 м², 33 хувь нь 12-50 м², 11 хувь нь 101-200 м², 5 хувь нь 201 м²-с дээш талбайтай байранд үйл ажиллагаа явуулж байна. 30 гаруй хувь нь 1 хүүхдэд ногдох зай талбайн хэмжээ маш бага хангалтгүй орчин нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2.1.4 Өдөр өнжүүлэх төвүүдийн байрны талбайн хэмжээ, дүнд эзлэх хувиар




Нийт өдөр өнжүүлэх төвүүдийн 53 хувь нь 1-2 жил, 20 хувь нь 2-3 жил, 18 хувь нь 4-с дээш жил, 9 хувь нь 3-4 жилийн турш үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнчлэн хамгийн олон жил буюу 14 жил үйл ажиллагаа явуулсан өдөр өнжүүлэх Улаанбаатар хотод байна. ӨӨТ-үүдийн 50 гаруй хувь нь анхны жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтвор суурьшилтай үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Зураг 2.1.5 Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагаа явуулсан хугацаа, дүнд эзлэх хувиар




Төлбөрийн хувьд 66 хувь нь 100.000-200.000 төгрөг, 25 хувь нь 201.000-300.000 төгрөг, 8 хувь нь 100.000 төгрөг, 1 хувь нь 301.000-400.000 төгрөгийн хооронд тус тус хэлбэлзэж байна. Хамгийн бага төлбөртэй өдөр өнжүүлэх сарын 30.000 төгрөг байхад хамгийн өндөр төлбөртэй нь 400.000 төгрөг байна. Сарын дундаж төлбөр нь 165.000 төгрөг байгаа нь төлбөрийн хувьд нэг их өндөр биш боломжийн гэж үзэж болохоор байна.

Зураг 2.1.6 Өдөр өнжүүлэх төвүүдийн сарын дундаж төлбөр, дүнд эзлэх хувиар




Өдөр өнжүүлэх төвүүдийн 40 орчим хувь нь хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх хөтөлбөртэй ба үүнд шатар, гар урлал, уран зураг, англи хэл, IQ, гитар, төгөлдөр хуур зонхилж байна. 60 орчим хувь нь хүүхэд хөгжүүлэх ямар ч хөтөлбөргүй байна. ӨӨТ-үүд нь ямар хөтөлбөртэй байх талаар тодорхойлж өгөх шаардлагатай.

Зураг 2.1.7 Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх хөтөлбөрүүд, дүнд эзлэх хувиар




Зураг 2.1.8 Өдөр өнжүүлэх төвүүдийн багшийн тоо, дүнд эзлэх хувиар

Нийт өдөр өнжүүлэхийн 65 хувь нь 1-2 багштай, 31 хувь нь 3-4 багштай, 4 хувь нь 5 болон түүнээс дээш багштай үйл ажиллагаа явуулж байна.



2.2 ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ ТӨВҮҮДИЙН БАГШ НАРЫН МЭДЭЭЛЭЛ

Зураг 2.2.1 Багшийн хүйсийн харьцаа, дүнд эзлэх хувиар




Өдөр өнжүүлэх төвд ажиллаж буй багш нарын 94 хувь нь эмэгтэй, 6 хувь нь эрэгтэй багш байна.

Зураг 2.2.2 Багшийн боловсролын төвшин, дүнд эзлэх хувиар




Боловсролоор нь авч үзвэл 92 хувь нь дээд дээд боловсролтой үүнээс 0.7 хувь буюу 3 хүн докторант, 2.8 хувь буюу 12 хүн магистрын зэрэгтэй байна.

Зураг 2.2.3 Насны бүлэг, дүнд эзлэх хувиар




Насны хувьд 30 хувь нь 24 хүртэлх, 34 хувь нь 25-34 насны, 21 хувь нь 35-44 насны, 15 хувь нь 45-с дээш насны багш нар ажиллаж байна.

Зураг 2.2.4 Нийт ажилласан жил, дүнд эзлэх хувиар




Өдөр өнжүүлэхийн багш нарын 2 хүний нэг нь 10 болон түүнээс дээш, 6 хүний нэг нь анхны жилдээ тус тус ажиллаж байна.

Зураг 2.2.5 Эзэмшсэн мэргэжил, дүнд эзлэх хувиар



Өдөр өнжүүлэх төвүүдийн багш нарын 70 гаруй хувь нь аль нэг чиглэлийн багшийн мэргэжилтэй бөгөөд тэдний ½ нь бага ангийн багш мэргэжилтэй байна. Үүний дараагаар цэцэрлэгийн болон монгол хэлний багш зонхилж байна.


Зураг 2.2.6 Давхар ажил эрхлэлт, дүнд эзлэх хувиар



Өдөр өнжүүлэх төвүүдийн багш нарын 3 хувь нь давхар ажил эрхэлдэг ба тэдний дийлэнх нь ЕБС-д багшаар ажилладаг байна.


2.3 ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ ТӨВИЙН ХҮҮХДҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

Зураг 3.3.1 Хүүхдийн насны бүлэг, дүнд эзлэх хувиар



Өдөр өнжүүлэх төвд хамрагддаг хүүхдүүдэд 6-8 насныхан 75 хувийг, 9-11 насныхан 24 хувийг, 1 хувийг бусад насныхан эзэлж байна. хүйсийн хувьд эрэгтэй 52 хувь, эмэгтэй 48 хувь байна. 70 гаруй хувь нь 6-8 насны буюу бага ангийн 1-2-р ангийн хүүхдүүд ихэвчлэн өдөр өнжүүлэх төвд хамрагдаж байна.

Зураг 3.3.2 Өдөр өнжүүлэхэд хамрагдсан хугацаа, дүнд эзлэх хувиар



Хүүхдүүдийн дийлэнх буюу 89 хувь нь анхны жилдээ, 6 хувь нь 2 дахь жилдээ, 5 хувь нь 3 болон түүнээс дээш жилдээ өдөр өнжүүлэх төвд хамрагдаж байна.

2.4 ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хүснэгт 2.4.1

№	Асуулт	Байгаа	Байхгүй
ДҮРЭМ, ЖУРАМ, ГЭРЭЭ, БҮРТГЭЛ			
1	Ажилчдын гэрээ	34.0	66.0
2	Эцэг эхтэй байгуулсан гэрээ	51.0	49.0
3	Хүүхдийн анкет	47.0	53.0
4	Ирцийн бүртгэл	71.0	29.0
5	Хүүхэд хамгааллын бодлогын дүрэм	15.0	85.0
6	Үйл ажиллагааны дотоод журам	30.0	70.0
7	Аюулгүй ажиллагааны дүрэм	25.0	75.0
8	Эрүүл ахуйн дотоод дүрэм	27.0	73.0
ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ			
9	Эрүүл ахуйн орчин нөхцөл агааржуулалтын систем	46.0	54.0
10	Тоосжилтын эсрэг авах үйлчилгээ	40.0	60.0
11	Гарын ариун цэвэр сахих булан	43.0	57.0
12	Ариутгалын бодисын хэрэглээ хадгалалт	46.0	54.0
13	Сав суулга, ариун цэврийн халдваргүйжүүлэлт	38.0	62.0
14	Анхны тусламжийн цүнх	40.0	60.0
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ			
15	Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичиг	28.0	62.0
16	Хоолны цэс технологи карт	44.0	56.0
17	1 хүүхдэд ногдох хоолны орц хэмжээ	32.0	68.0
18	Тогоочтой эсэх	49.0	51.0
19	Гал тогооны өрөө	87.0	13.0
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ			
20	Галын булан	28.0	72.0
21	Галын дүгнэлт	25.0	75.0

Нийт өдөр өнжүүлэх төвүүдийн 15 хувь хүүхэд хамгааллын бодлогын дүрэмтэй бөгөөд тэдний 80 хувь нь ажилтнуудад хүүхэд хамгааллын дүрмийг мөрдөж ажиллах гарын үсэг зуруулж, байгууллагын самбарт ил байрлуулсан байна. Мөн 53 хувь нь хүүхдийн анкетын мэдээлэл, 30 хувь нь үйл ажиллагааны дотоод журам, 66 хувь нь ажилчдын гэрээ, 49 хувь нь эцэг эхтэй байгуулсан гэрээ байхгүй байна.

Эрүүл ахуйн орчин нөхцөл агааржуулалтын систем, ариутгалын бодисын хэрэглээ хадгалалт, гарын ариун цэвэр сахих булан, сав суулга, ариун цэврийн халдваргүйжүүлэлт зэрэг нь хангалтгүй байгаа бөгөөд 60 гаруй хувьд нь байхгүй байна. Түүнчлэн 70 гаруй хувь нь галын булан, галын дүгнэлт, аюулгүй ажиллагааны дүрэм байхгүй байна.



БҮЛЭГ III

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ


3.1 ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ, ҮНЭЛГЭЭ

Зураг 3.1.1 Эцэг эхийн ажил эрхлэлт, дүнд эзлэх хувиар




Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 42 хувь нь хувийн хэвшил, бизнесийн байгууллага, 23 хувь нь төрийн байгууллага, 22 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8 хувь нь ажилгүй байна.

Зураг 3.1.2 Хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чаддаг эсэх




Өдөр өнжүүлэх төв хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чаддаг гэдэгтэй санал нийлэх үү? гэсэн асуултад 51 хувь нь бүрэн санал нийлнэ, 41 хувь нь санал нийлнэ, 8 хувь нь хангалтгүй болон мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 3.1.3 Хүүхдийн тоо, дүнд эзлэх хувиар



Өдөр өнжүүлэхэд хүүхдээ өгдөг эцэг эхийн 35 хувь нь 1 хүүхэдтэй, 31 хувь нь 2 хүүхэдтэй, 34 хувь нь 3 болон түүнээс дээш хүүхэдтэй байна.

Зураг 3.1.4 Өдөр өнжүүлэхэд явдаг хүүхдийн тоо, дүнд эзлэх хувиар




Эцэг эхчүүдийн 89 хувь нь 1 хүүхэд, 9 хувь нь 2 хүүхэд, 2 хувь нь 3 хүүхэд өдөр өнжүүлэх төвд хамруулдаг гэж хариулжээ.

Зураг 3.1.5 Өдөр өнжүүлэх төвд хамрагдсанаар үр дүн, эерэг өөрчлөлт гарсан эсэх




Өдөр өнжүүлэх төвд хамрагдсанаар 59 хувь нь маш сайн нөлөөтэй, 38 хувь нь нөлөөтэй ч сайжруулах зүйл бий, 3 хувь нь ямар ч нөлөөгүй гэж эцэг эхчүүд хариулсан байна. Үүнээс үзэхэд хүүхдүүд өдөр өнжүүлэх төвд явах нь үр өгөөжтэй боловч цаашид сайжруулах зүйлс байгааг харуулж байна.

Зураг 3.1.6 Өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагааг бүхэлд нь үнэлнэ үү?




Өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагаанд эцэг эхчүүд сэтгэл байна. Гэхдээ эцэг эхчүүд өдөр өнжүүлэх төвүүдийн стандарт, шаардлага ямар байх талаар мэдлэг дутмаг бөгөөд зөвхөн гэрийн даалгавар хийлгэж өгдөгт нь л сэтгэл хангалуун байдаг байна.

Зураг 3.1.7 Хүүхдүүд өдөр өнжүүлэх төвд хэдэн цаг явдаг, дүн эзлэх хувиар



Өдөр өнжүүлэх төвд хүүхдүүдийн 45 хувь нь 3-5 цагийг, 29 хувь нь 5-7 цагийг, 20 хувь нь 7-с дээш цагийг, 6 хувь нь 3-с доош цагийг өнгөрүүлдэг байна.

Зураг 3.1.8 Хоол ундны чанарын үнэлгээ, дүнд эзлэх хувиар



Өдөр өнжүүлэх төвүүдийн хоолны чанарыг 78 хувь нь хангалттай, 12 хувь нь дунд зэрэг гэж эцэг, эхчүүд үнэлсэн байна. Харин 8 хувь нь хоолгүй бөгөөд гэрээсээ бэлтгэж ирдэг байна.



БҮЛЭГ IV

ДҮГНЭЛТ

4.1 ДҮГНЭЛТ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн газраас улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх өнжүүлэх төвүүдийг судалгаанд хамруулахыг хичээсэн боловч хаягжилтын байдал тодорхойгүй, албан ёсны бүртгэл мэдээлэл байхгүйн улмаас өнөөдрийн байдлаар яг хэдэн өдөр өнжүүлэх төв үйл ажиллагаа явуулж байгааг тогтооход хүндрэлтэй байлаа. Гэсэн хэдий ч уг судалгаанд нийслэлийн 8 дүүрэг, орон нутгийн 14 аймгийн 282 өдөр өнжүүлэх төвүүдийг хамруулсан нь тэдний үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлоход хангалттай төлөөлөл болно гэж үзэж байна.

Өдөр өнжүүлэх төвүүд нь тогтворгүй үйл ажиллагаатай бөгөөд 75 хувь нь 1-3 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хүүхдүүдийнх 80 хувь нь анхны жилдээ хамрагдаж байна. Мөн тэдний 74 хувь нь орон сууцны нэг, хоёр өрөөг тохижуулж үйл ажиллагаа явуулж байгаа боловч орон байрны дийлэнх буюу 77 хувь нь өөрийн эзэмшлийн бус түрээсийн байр тул орон байраа хүүхдэд тохирсон орчин бүрдүүлж, засаж тохижуулах байдал хязгаарлагдмал байгаа нь ажиглагдлаа.

Хэрэглэгчийн үнэлгээг авч үзвэл ихэнх хувь нь хичээлийн даалгавар хийлгэж, өдөрт харах хүнтэй байдагт нь сэтгэл хангалуун байдаг бөгөөд хүүхдийг хөгжүүлэх нэмэлт хөтөлбөр болон бусад зүйлсэд нь ач холбогдол өгдөггүй байна.

Цаашид үйл ажиллагааг нь сайжруулахад дараах саналуудыг дэвшүүлжээ.

- Төрөөс нэгдмэл зөв бодлогоор дэмжих
- Боловсон хүчнийг чадавхжуулах, ахмад туршлагатай багш нарын ажиллах боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах
- Эрүүл ахуйн орчинг онцгой анхаарах
- Тогтсон стандарттай болгох
- Хувийн цэцэрлэгийн адилаар хувьсах зардал олгох

Судалгааны дүнгээс үзэхэд өдөр өнжүүлэх төвүүдэд төлөвшилтийнхөө гол суурийг олж авах насны хүүхдүүд ихэвчлэн хамрагдаж байгаа бөгөөд дөрвөн хүүхэд тутмын гурав нь 6-8 насныхан байна. Сургуулийн насныхан хичээлийн хөтөлбөрөөс гадуур мэдлэг хуримтлуулах, өөрийгөө хөгжүүлэх, бусад хэлбэрээр оюунаа цэнэглэх шаардлага бий. Гэтэл судалгаагаар өдөр өнжүүлэх төвүүдийн дөнгөж 30 гаруй хувь нь хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх шатар, гар урлал, уран зураг, IQ, гитар, төгөлдөр хуур гэх мэт хөгжлийн хөтөлбөрүүдтэй боловч зарим төвүүд хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагаа нь жигдрээгүй, нэр төдий байгааг дурдах нь зүйтэй.

Өдөр өнжүүлэх төвүүдийн 75 хувьд нь багшийн мэргэжилтэй хүн ажиллаж байгаа бөгөөд тэдний дийлэнх нь бага анги, цэцэрлэг, монгол хэлний багшийн мэргэжилтэй байгаа нь сайшаалтай боловч цөөнгүй тохиолдолд зарим өдөр өнжүүлэх төвийн багш нар ерөнхий боловсролын сургуульд давхар багшаар ажиллаж байна. Энэ нь багш нар ажлын найман цагийн турш ажил буюу сургууль дээрээ байх ёстой болдог. Гэтэл өдөр өнжүүлэх төв ажиллуулаад

өөрсдөө тэндээ багшлах, хүүхдүүдтэй ажиллах боломж нь хязгаарлагдмал болдог учраас мэргэжлийн бус хүмүүст хүүхдүүдийг даатгаж орхих нөхцөлийг бүрдүүлж байна.

Эцэг эхчүүдийн 90 гаруй хувь нь өдөр өнжүүлэх төв хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чаддаг гэж үзсэн боловч бодит байдал дээр хүүхэд хамгааллын нөхцөл байдал хангалтгүй байлаа. Тухайлбал өдөр өнжүүлэх төвүүдийн 85 хувь нь хүүхэд хамгааллын бодлогын дүрэмгүй, 50 хувь нь эцэг эхтэй байгуулсан гэрээгүй, 70 орчим хувь нь ажилчдын гэрээ болон аюулгүй ажиллагааны дүрэм, галын булан, галын дүгнэлт тус тус огт байхгүй байгаа нь үйл ажиллагаа явуулах нэгдсэн стандарт, дүрэм журам шаардлагатай байгааг харуулж байна. Түүнчлэн эрүүл ахуйн орчин нөхцөл хангалтгүй бөгөөд хоёр өдөр өнжүүлэх төв тутмын нэг нь агааржуулалтын систем, ариун цэврийн булан, ариутгалын бодисын хэрэглээ хадгалалт, сав суулга ариун цэврийн халдваргүйжүүлэлт байхгүй, дөрвөн өдөр өнжүүлэх төв тутмын гурав нь хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиггүй ажиллаж байна.

Өдөр өнжүүлэх төвүүд нь харилцан адилгүй байгаа нь нэгдсэн стандарт байхгүй байгаатай холбоотой бөгөөд судалгаанд хамрагдсан өдөр өнжүүлэх төвүүд дараах сургалтын арга зүй хэрэгцээ, шаардлагатай байна гэж үзжээ. Үүнд:

- Хүүхдийн эрхийн чиглэлээр сургалтад хамрагдах, мэдээлэл авах
- Өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хүүхэд хамгааллын асуудлаарх хууль эрх зүй, тэдгээртэй холбогдох дүрэм, журмын сургалт
- Хүүхэд хоорондын харилцааны сургалт явуулах
- Хүүхдийн хүмүүжил төлөвшилт сэтгэл зүйд нөлөөлөх арга зүйн сургалт
- Хүүхдийн хөгжүүлэх арга зүйн сургалт
- Хүүхдийн насны онцлогоор хөгжүүлэх мэргэжил арга зүй сургалт
- Эрүүл ахуй, ариун цэврийн сургалт
- Өдөр өнжүүлэх төвүүдийн хөтөлбөрийг арга зүйн нэг стандарттай болгох
- Боловсон хүчний тогтворгүй байдалд анхаарал хандуулах зэрэг саналуудыг дэвшүүлжээ.

Цаашид өдөр өнжүүлэх төвүүдийг ашигтай ажилладаг бизнесийн байгууллага бус хүүхдийн хөгжлийн хамгийн эхний суурь тавигддаг цэцэрлэгийн боловсролтой дүйх боловсролын салбарын нэг хэсэг хэмээн үзэн, төрийн бодлогын хэмжээнд эрх зүйн орчныг тодорхойлж өгөх шаардлагатай гэж үзэж байна.

ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ ТӨВӨӨС АВАХ СУДАЛГААНЫ АСУУЛГА

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Сургалт, судалгаа, мэдээллийн төвөөс нийслэлийн өдөр өнжүүлэх төвийн өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор уг судалгааг явуулж байна. Энэхүү асуулгаар авсан мэдээллийн нууцыг Монгол Улсын “Байгууллагын нууцын тухай” хууль болон “Статистикийн тухай” хуулийн дагуу чандлан хадгалж, зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах олно.

№	Асуулт	Хариулт
1	Байршил	Аймаг/ Нийслэл
		Сум/ Дүүрэг
		Баг/ Хороо.....
		Байр, тоот
2	Ерөнхий мэдээлэл	Төвийн нэр
		Эзэмшигчийн нэр
		Байгуулагдсан огноо.....
		Үйл ажиллагаа явуулсан хугацаа жил сараар
3	Үйл ажиллагаа явуулдаг байрны өмчийн хэлбэр	1. Өөрийн 2. Түрээсийн
4	Үйл ажиллагаа явуулдаг орчин нөхцөл	1. Орон сууцны өргөтгөл 2. Орон сууцны нэг давхарт 3. Орон сууцны 2 болон 2-с дээш давхарт 4. Сургууль, цэцэрлэгийн байр 5. Монгол гэрт 6. Бусад.....
5	Нийт талбайн хэмжээ	/ м2/
6	Үйлчилгээний төлбөр /нэг хүүхдээр/	/...../ сарын дундаж дүн/
7	Ажиллах цагийн хуваарь	1. Эхлэх цаг /...../ 2. Дуусах цаг /...../
8	Үндсэн багшийн тоо	1. 1-2 2. 3-4 3. 5-с дээш
9	Сонгон, дугуйлангийн багшийн тоо	1. 1 2. 2 3. 3-с дээш 4. Байхгүй
10	Хамрагдаж байгаа нийт хүүхдийн тоо	/...../
11	Хамрагдаж байгаа хүүхдийн тоо /хүйсээр/	1. Эрэгтэй /...../ 2. Эмэгтэй /...../
12	Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо/	/...../
13	Хамрагдаж байгаа хүүхдийн нас	1. 5-6 нас /...../ 2. 7-8 нас /...../ 3. 9-10 нас /...../ 4. 11-12 нас /...../ 5. 13-14 нас /...../ 6. 14-с дээш /...../
14	Хичээл хийх өрөөтэй эсэх	1. Байгаа 2. Байхгүй 3. Тоглоомын өрөөтэй цуг
15	Тоглоомын өрөөтэй эсэх	1. Байгаа

		2. Байхгүй 3. Хичээлийн ерөөтэй цуг
16	Гал тогооны ерөөтэй эсэх	1. Тийм 2. Үгүй
17	Танай төвд ямар сургалт, арга зүйн хэрэгцээ байна вэ?	/...../

Маягт №1. Багшийн мэдээлэл

№	Овог нэр	Нас	Хүйс	Боловсролын зэрэг	Эзэмшсэн мэргэжил	Ажилласан жил	Давхар ажил эрхэлдэг эсэх
1							
2							
3							
4							
5							
6							
7							

Маягт №2. Төвийн дотоод үйл ажиллагаа

Хүүхдийн хөгжил, хамгааллын байдал		
№	Асуулт	Хариулт
1	Хүүхэд хамгааллын бодлого, дүрэмтэй эсэх	1. Тийм 2. Үгүй ↓ 4 рүү үсрэх
2	Ажилтнуудад хүүхэд хамгааллын дүрмийг мөрдөж ажиллах заавар өгч , гарын үсэг зуруулсан эсэх	1. Тийм 2. Үгүй
3	Хүүхэд хамгааллын бодлогыг байгууллагын дүрэмд оруулж самбарт ил байршуулсан эсэх	1. Тийм 2. Үгүй
4	Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх ямар хөтөлбөртэй вэ? /олон сонголттой/	a. Шатар, даам b. IQ c. Соропон сампин d. Бусад..... e. Байхгүй

		Байгаа	Байхгүй	Төлөвлөсөн	Судалсан	Тайлбар
5	Үйл ажиллагааны дотоод журам					
6	Ажилчдын гэрээ					
7	Хүүхдийн анкет					
8	Эцэг эхтэй байгуулсан гэрээ					
9	Ирцийн бүртгэл					

Байрны орчин, аюулгүй байдал

10	Галын булан					
11	Галын дүгнэлт					
12	Анхны тусламжийн цүнх					
		Байгаа	Байхгүй	Төлөвлөсөн	Судалсан	Тайлбар
13	Аюулгүй ажиллагааны дүрэм					
14	Агааржуулалтын систем					
15	Тоосжилтын эсрэг авах үйлчилгээ					
16	Худалдан авалтын бүртгэл					
17	Эрүүл ахуйн дотоод дүрэм журам					
18	Ариутгалын бодисын					

	хэрэглээ, хадгалалт					
19	Үйлчилгээний ажилтны ажил үүргийн хуваарь					
20	Өдөр тутмын ажлын хуваарилалт					
21	Гарын ариун цэврийг сахих булан					
22	Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн шинжилгээний бичиг					
23	Гал тогоо тусдаа, хооллох ширээ сандлын хүртээмж					
24	Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт					
25	Хоолны меню, технологийн карт					
26	Хоолны орц, нэг хүүхдэд ногдох хэмжээг тодорхойлох					
27	Сав суулга, аяга тавгийн ариун цэврийн халдваргүйжүүлэлт					
28	Шингэн уух зүйл хангалттай байдаг эсэх					
29	Тогоочтой эсэх		Асуулгыг дуусгах			
30	Тогоочийн ажил байдлын тодорхойлолт, шинжилгээний бичиг					
31	Тогоочийн хувцас, хэрэглэл, шүлсэвч					

ЭЦЭГ ЭХЭЭС АВАХ СУДАЛГААНЫ АСУУЛГА

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Сургалт, судалгаа, мэдээллийн төвөөс нийслэлийн өдөр өнжүүлэх төвийн өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор уг судалгааг явуулж байна. Энэхүү асуулгаар авсан мэдээллийн нууцыг Монгол Улсын “Хувь хүний нууцын тухай” хууль болон “Статистикийн тухай” хуулийн дагуу чандлан хадгалж, зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах болно.

№	Асуулт	Хариулт
1	Таны оршин суугаа хаяг	Аймаг/ Нийслэл Сум/ Дүүрэг Баг/ Хороо..... Байр, тоот
2	Таны нас	1. 24-хүртэлх 2. 25-34 3. 35-44 4. 45-54 5. 55-аас дээш
3	Таны хүйс	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
4	Таны ажил эрхэлдэг салбар	1. Төрийн байгууллага 2. Хувийн байгууллага 3. Олон улсын байгууллага 4. Хувиараа хөдөлмөр эрхлэгч 5. Тэтгэвэрт 6. Ажилгүй
5	Танайх хэдэн хүүхэдтэй вэ ?	1. 1 2. 2 3. 3 4. 4-өөс дээш
6	Өдөр өнжүүлэхэд явдаг хүүхдийн тоо	1. 1 2. 2 3. 3 4. 4-өөс дээш
7	Өдөр өнжүүлэхэд явдаг хүүхдийн нас	1. 2. 3. 4.
8	Өдөр өнжүүлэх төвд хүүхдээ өгч авдаг цаг	1. Өгөх цаг /...../ 2. Авах цаг /...../
9	Танай хүүхэд өдөр өнжүүлэхэд өдөрт хэдэн цаг явдаг вэ?	1. 3-с доош 2. 3-5 цаг 3. 5-7 цаг 4. 7-с дээш
10	Өдөр өнжүүлэх төвүүд хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чаддаг гэдэгтэй санал нийлдэг үү?	1. Бүрэн санал нийлнэ 2. Санал нийлнэ 3. Хангалтгүй 4. Мэдэхгүй
11	Өдөр өнжүүлэх төвүүдэд хүүхдийг хөгжүүлэх хөтөлбөр хангалттай байдаг уу?	1. Хангалттай 2. Дунд зэрэг 3. Хангалтгүй 4. Мэдэхгүй
12	Танай хүүхэд өдөр өнжүүлэх төвийн хөтөлбөрт хамрагдсанаар гарсан үр	1. Маш сайн нөлөөтэй 2. Нөлөөтэй ч сайжруулах зүйл бий

	дүн, өөрчлөлт бий юу ?	3. Маш бага 4. Огт нөлөөгүй
13	Хүүхдийн хоол ундны чанарыг үнэлнэ үү?	1. Хангалттай 2. Дунд зэрэг 3. Хангалтгүй 4. Мэдэхгүй
14	Үйлчилгээний төлбөр /нэг хүүхдээр//сарын дундаж дүн /
15	Үйлчилгээний төлбөрт та хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	1. Хангалттай 2. Дунд зэрэг 3. Хангалтгүй 4. Мэдэхгүй
16	Тухайн өдөр өнжүүлэх төвийг бүхэлд нь үнэлбэл та хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	1. Хангалттай 2. Дунд зэрэг 3. Хангалтгүй 4. Мэдэхгүй

17. Цаашид өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар таны санал, сэтгэгдэл юу байна вэ ?

.....

.....

.....

.....

.....

Судалгаанд хамрагдсанд баярлалаа